



## МОНГОЛ АРДЫН БОЛОН ХЯТАД АРДЫН ҮЛГЭР ДЭХ ӨНЧИН ХҮҮГИЙН ДҮРИЙН ОНЦЛОГ

С. Хөвсгөл, М. Баттунгалаг, МУБИС

### Abstract

In the Asian folk-stories, the role of the orphan boy reflects the special features of the people's way of living. It loathes the corrupt affairs rich people and nobles, desires the free and happy life and reflects the honored attempts of the ethics. In the foreign countries folk-stories the depiction of harming the youngest brother when they divide their heritage is described frequently. This could be a feature of the settled civilization. In Mongolian folk-stories the role of the orphan boy representing the common people is in opposition of the roles of the rich and ungenerous people representing the lords and kings. In the Mongolian folk-stories and Mongolian race folk-stories the wisdom and hardworking nature of the people is praised as well as telling about the important principles to be honest, respect and care the parents and elder people to the kids. The similar thing of the folk-stories are they contain the intention of greediness does not approach to the good things. The role of the orphan boy and youngest son is the honest, humane, helpful and generous role. In the end the roles of the orphan boys reflect the social communication. This thesis is required to be studied further and widely. In all countries tales are include some culture.

### Түлхүүр үг

Аман зохиол дахь соёлын үнэлэмж, харьцуулалт, өнчин хүү, дүр

### Удиртгал

Аливаа улс орны аман зохиолыг нийгэм судлалын талаас ард түмний бүтээл туурвилын нэгэн хэлбэр, тэдний сэтгэл сэтгэгдлийг илтгэгч, нийгмийн сэтгэл зүйн илэрхийлэл гэдэг талаас нь судалж болох бол соёл судлалд аман зохиолыг үндэсний соёлыг бүтээгч үүргийн талаас нь судлан шинжилж болно. Үлгэр дэх дүрүүд нь өөр өөрийн улс орны онцлог, зан заншил, бэлгэдэл, түүх соёлыг шингээсэн ард түмний үзэл санааг илэрхийлэгч дүр байж чаддагаараа онцлог болохыг дурдах нь зүйтэй.

Монгол ардын үлгэрийг судалсан гол төлөөлөгчдийг дурдвал Б.Ринчен, Ц.Дамдинсүрэн, П.Хорлоо, Ш.Гаадамба, Х.Сампилдэндэв, Д.Цэрэнсодном, Б.Лхамсүрэн, Б.Дашзэвэг, Ж.Надмид, Р.Нарантуяа, Б.Дайриймаа нар юм. Хятад ардын үлгэрийг судалсан гол төлөөлөгчдийг дурдвал Сэцэнмөнх, Д. Бат, Мандах, Хай-Ин, Л. Данганжав, Чен Цогта, Зэнээ, Сарантуяа, Цен Ган Лүнг нар болно.

Монгол ардын үлгэр болон Хятад ардын үлгэрт өнчин хүүгийн дүрийг дүрсэлсэн байдлыг ажиглаж үзвэл, тухайн үлгэрт тэр үеийн ард түмний соёлын уламжлалыг хадгалсан, үлгэр дэх өнчин хүүгээр ядарч зүдэрсэн ч гэсэн үнэнч шударга, сэргэлэн ухаантай, хүнлэг ёс суртахууныг хадгалсан, харц ардын төлөөлөл болсон байдаг нь нийтлэг шинжтэйг илтгэнэ. Гэхдээ өнчин хүү нь үлгэрт ядуу хоосон, тарчиг

амьдралтай; өргөмөл; өнчин өрөөсөн; дагавар хүү гэх мэтээр дүрслэгдэж байгаа бөгөөд уг дүр нь үлгэрт баяд ноёдод дарлагдсан дүр хэдий ч үнэнч шударга байсныхаа эцэст аз жаргалынхаа эзэн нь болж чаддаг гэдгийг харуулсан баатарлаг дүр болно. Өнчин хүүгийн дүрийг тусгасан үлгэрийг улс хооронд нь харьцуулан судалсан судалгаа одоогоор бидэнд хараахан байхгүй тул улс үндэстний өрөвдөлтэй, баатарлаг өнчин хүүгийн дүрийн уран дүрслэхүүн болоод олон янзын ялгаа гарна. Тиймээс уг үлгэрүүд дэх өнчин хүүгийн дүрийг харьцуулан судлах нь чухал бөгөөд сонирхолтой судалгаа болно гэж бид хувьдаа үзэж байна.

### Судалгааны үндсэн хэсэг

Монгол ардын “Өнчин Бэглэг”, “Өнчин Бүш хүү” үлгэрүүд, Хятад ардын “Шидэт бийр”, “Алтан сүх” үлгэрүүдийг дүрийн онцлог, сургамжит санаа, нийгэм ахуй, соёл талаас нь харьцуулан авч үзье.

“Өнчин Бэглэг” үлгэрт Бэглэг хүү нэг морьтой бөгөөд өнөөх морио чонын хаанд идүүлчихсэнээр үлгэр эхэлнэ. Чонын хаан, хүүгээс “За чи надаас юу авах вэ?” гэхэд тэр хойморт байгаа алтан хайрцагтай юмыг авъя гэв. (Монгол ардын аман зохиолын дээж бичиг, 1978) Маргааш өглөө харахад ямар ч айлгүй газар нэг

\* s.khuvsgul@yahoo.com

гэрт сайхан бүсгүй өнчин Бэглэг хүүгийн хамт аж төржээ. Хүү адуу мал олонтой сайхан амьдарч байгааг нь харсан Чинжи Жалбайн Жамцаран хаан, хүүгийн эхнэрийг яаж өөрийн болгох вэ хэмээн бодсоор Бэглэг хүүтэй хоёр удаа нуугдан, үхсэн хүний үлээ, хатсан хүний хальс олж ирэх даалгавар өгдөг билээ. Бэглэг хүүг эхнэр нь мөнгөн хуруувч, мөнгөн зул болгож нуужээ. Хаан Бэглэг хүүг ганц ч олсонгүй. Хаан дараа өдрүүдэд нь орны хойно шар цоохор их сайхан нум, тэмээний нь мөнгөн буйлан дотор орж тус тус нуугджээ. Бэглэг хүү эхнэрийнхээ тусламжтай олсоор л байв. Хаан түүнийг олж чадаагүй учир түүнд “Маргааш чи үхсэн хүний үлээ, хатсан хүний хальс олж ир” (1978, х.159) гэв. Бэглэг хүү эхнэрийнхээ аав ээжийн хэлснээр бүх учраа хэлтэл Эрлэг номун хаан үхсэн хүний үлээ, хатсан хүний хальс өгөөд “Тэр хааныгаа ирж уулз” гэжээ. Өнчин Бэглэг хаандаа өнөөхөө өгөөд, өнөөх үгийг хэлтэл хааны толгой тасарчээ. Түүнээс хойш хүү амар сайхандаа жаргажээ. Өнчин Бэглэг хүү нэг морьтой, нэг журга нумтай байж. “Морийг нь идсэн чоныг алах гэж байснаас нь” (1978, х.159) харвал Өнчин Бэглэг хүү анхийж, өдөр хоногийг өнгөрүүлдэг байсан байна. Мөн журга нумтай бөгөөд түүнийгээ ашиглан чоныг устгах гэсэн оролдлого нь мөн нотолж байна.

“Өнчин Бүш хүү” үлгэрийн Түс гэдэг годилоороо нэг харвахад 312 шувуу онодог энэ Түс гэдэг годил бол агнуурын хэрэгсэл бөгөөд үүнийг сайжруулах гэсэн анчин ардын санааг илэрхийлсэн. Тариач хаанд өргөл барьц өгч, охиныг гуйсанд хаан уурлаж, түүний гар, хөлийг мөчилж, хээр хаяжээ. Гэтэл хүүгийн зүүдэнд цал буурал цагаан сахалтай өвгөн цагаан мөнгөн таяг гартаа барьж харагдан, аманд нь нулимж, цээжээр нь цагаан мөнгөн таягаараа хоёр гурав цохиод “За хөвгүүн! Хөл, гар, нүд чинь эдгэг. “Мууд үзсэнээ наалданхаш, сайнд үзсэнээ бусраад” гээд явсанд нүд, гар, хөл нь ургаснаар үл барам, харгис хаанаас өшөөгөө авах шидэт хоёр үгтэй болсноор санасандаа хүрч хааны охиныг гэргийгээ болгоно.” (Монгол аман зохиолын тайлбарт дээж бичиг, 2011) гэсэн нь цагаан сахалт өвгөний бэлгэдлийн утгыг агуулсан хэсэг болно. Хааны хатныг анагаахаар “бөө хүн цагаан малгайгаа өмсөөд, цагаан дээлээ өмсөөд, цагаан морио унаад гараад явав” (2011, х.502) гэсэн хэсгээс бөөгийн ёс, ахуй соёлын тусгалыг илэрхийлсэн. Уг үлгэрээс ажиглахад Бүш хүү годилоороо анхийж, голоо зогоодог харц хүүгийн дүр юм. Мөн энэ үлгэрт Бүш хүүгийн дүрийг зальтай талаас дүрслэн өгүүлжээ. Яагаад гэвэл “Бүш хөвгүүн гурав хоногт ном уншмар болж, үлээмэр болж...”

(2011, х.503) гэсэн хэсгээс илэрхий ажиглагдаж байна.

“Шидэт бийр” Хятад ардын үлгэрт өнчин ядуу Ма-лин хүү элсэн дээр мөчрөөр зураг зурсаар зураач болдог нэгэн хүүгийн тухай үлгэр билээ. Түүнд “Урт буурал сахалтай өвгөн шидэт бийр бэлэглэв” гэж зүүдэлтэл, зүүд нь биелсэн байжээ. Уг бийрээр зурсан амьтан бүхэн амилдаг байв. Түүнээс хойш хүү “ядуучуудад зориулж анжисгүй хүнд анжис, сэрээгүй хүнд сэрээ зурж өгсөн нь” (*Шувууны хэл, 1997*) тусч болоод нинжин сэтгэлтэй гэдгийг харуулжээ. Ма-лин хүү амьтан, байгаль мөн ядуу хүмүүст хэрэгтэй зүйлийг нь л зурж өгдөг, харин хэзээ ч алт, зоос зурж өгдөггүй. Хүү амьтан зурахдаа нүдгүй зурдаг байсан. Тэгээд зурж байсан өрөвтасын нүүрэн дээр нь санамсаргүй бэх дустал өнөөх шувуу нисэхийг харсан хааны түшмэд эзэн хаандаа дуулгахад хүүг гянданд хорьж, бийрийг хураан авдаг билээ. Бийрийг хураан авсны учир гэвэл бийрээр овоолсон их алт зурж, баяжих санаатай байсан. Хаан эхлээд “их алт зурахад нь чулуу, бүр том алт зуртал аварга том могой болон хувирч байгаа” (1997, х.6) нь шидэт бийрээр шунахай хүн алт мөнгө, эд хөрөнгө зурсан ч тэр нь биелэхгүй гэсэн санааг гаргасан. Ингээд өнөөх хаан уурлан хүүгээр далай, хөлөг онгоц, салхи зуруултал, хаан хөлөг онгоцтойгоо холхи алсад одон, алга болов. Түүнээс хойш хэн ч хааныг хараагүй.

“Шидэт бийр” үлгэр нь шунахай, хорон санааны уршгийн тухай өгүүлдэг ба баян газрын эзэн болоод улсын хаанаар “хүн хэдий чинээ эрх мэдэл, эд хөрөнгө ихтэй байна төдий чинээ шунахай байдаг” гэснийг тусгасан. Мөн өнчин хүү Ма-лин бол харц ардын төлөөлөл бөгөөд баяд ноёдод дарлагдагч дүр болохыг тодотгон харуулсан.

“Алтан сүх” Хятад ардын үлгэрт Цзен Ши нэрт нэгэн ядуу хүү арван таван наснаасаа эхлэн газрын эзэн Ян Бэ Пигийнд аахар шаахар ажил хийж амь зогоодог. Тэрээр гол гарч яваад сүхээ усанд унагачихжээ. Цзен Ши хүү голд орж сүхээ эрсэн боловч ус гүн, урсгал ширүүн учир юу ч олж чадсангүй ажээ. Хятадын уран зохиолд бэлгэдэл болох лусын орноос урт цагаан сахалтай өвгөн болж хувиран гарч ирсэн Лусын эзэн таяг тулсаар ил гарч ирэв. Лусын эзэн хүүгийн зовуурт байдлыг өрөвдөн, түүний сүхийг авч өгөхөөр гол руу орчихов. Хүүгийн байдлыг харсан өвгөн хоёр удаа ус луу буцан орж, алтан сүх, мөнгөн сүх үзүүлэн асуухад “энэ минийх биш” хэмээв. Харин төмөр сүх харуулахад “Энэ харин минийх” (Сосорбарам Э. 1964. Алтан сүх) гэж хариулж байгаагаас дүгнэн үзэхэд шударга

агаад жаахан ч шунахай зан үгүйг гарган дүрсэлжээ. Цзен Ши хүү Лусын эзнээс сүх дамнуургаа аваад түлээгээ бэлдтэл жирийн өдрүүдээсээ илүү хурдан түлээгээ бэлджээ. Ян Бэ Пи газрын эзэн, Цзен Ши хүүг эрт ирснийг үзээд залхуу хойрго амьтан гэж хараах гэтэл цавчсан түлээ нь өмнөх өдрүүдээсээ арвин байгааг хараад хүүгээс бүх учрыг сонсов. Энэхүү үйл явдлаар хүүгийн эзэндээ хэр үнэнч байгааг харж болох юм. Уг яриаг сонссон газрын эзэн алтан сүхтэй болохын тулд зориуд сүхээ хаясанд ус цалгилян, сүх ч живэв. Лусын эзэн газрын эзэнд алт, мөнгө, төмөр сүх гаргаж ирэхэд “алтан сүх”-ийг энэ минийх гээд авав. Төд удалгүй гол дээр тавьсан модон дээгүүр алхалж яваагаа мартсан тэрээр “Одоо ч дэлхийн ганц баян болно доо” гэж үгээ хэлж дуусахаас өмнө ус луу унав. (1964, х.12) Ян Бэ Пи ч живэв. Алтан сүх ч алга болов. Муу муухай, шунахай сэтгэл аливаа хүнийг сайн зүйлд хүргэдэггүй гэсэн санааг харуулжээ.

Хүснэгт 1

Монгол ардын болон Хятад ардын үлгэрийн харьцуулалт

№	Үлгэр	“Өнчин Бэглэг”	“Өнчин Бүш хүү”	“Шидэт бийр”	“Алтан сүх”
1.	Үлгэрийн дүрийн онцлог	Өнчин Бэглэг хүү нэг морьтой, журга нумтай байгаа бөгөөд морийг нь идсэн чоныг алах гэснээс харвал ан хийж амьдардаг зоригтой хүү байна. Өнчин Бэглэг шидийн хүчээр хааныг дарж байгаа нь хаантай эн зэрэгцэн тэмцэж буй баатарлаг байдлыг гарган харуулжээ.	Бүш гэдэг өнчин хөвүүн аягын чинээ нууртай ба Түс гэдэг годилоороо ан хийн амьдардаг нэгэн. Өнчин Бүш хүүг гэх хүн байхгүй бөгөөд тэрээр өөрөө өөрийгөө болгодог сэргэлэн хүү гэдэг нь “Тэгээд шувуут хаандаа өргөөд хааны отгон хүүхэнтэй сууя уу гэж ирэв гэв. Хаан цухалдаж үүний нэг гар, нэг нүд, нэг хөлийг нь огтлоод эзгүй ээрэм талд аваачиж хаяв” (2011, х.502) гэсэн хэсэгт дүрслэгддэг.	Ма-лин (马良 ma liang) хүү бургас түүх болгондоо элсэн дээр мөчрөөр зураг зурж суудаг тэрээр бийр цаасгүй зураач болдог билээ. Ма-лин хүүгийн дүр бол “...анжисгүй хүнд анжис, сэрээгүй хүнд сэрээ зурж өгч байгаагаас” харахад тусч, өглөгч, нинжин сэтгэлтэй хүүгийн дүр мөн болно. Нутгийн баяд ноёд нь ядуу харц ардаа дарладаг.	Цзен Ши (程实 cheng-shi) хүү нийгмийн дарлагдсан дүрийн төлөөлөл мөн болно. Учир нь уг үлгэрт “өдөрт хэчнээн их ажил хийвч амраахгүй, мөрөнд нь дамнуурга, гарт нь сүх бариулан түлээнд явуулдаг байжээ” гэсэн үлгэрийн явдлаас илэрхий харагдаж байгаа болно. Ян Бэ Пи (张剥皮 zhangbaopi) нь хатуу ширүүн зантай, хайрлах энэрэхийг мэддэггүй дүр юм.
2.	Тухайн үлгэрт туссан нийгэм ахуй, соёлын тусгал	Морийг өөрийн хань гэж үздэг. Үлгэрт морь мал чухал үүргийг гүйцэтгэж байна. Мөн үлгэрт гарч байгаа дүр монголын ард түмний үндэсний болоод соёлын онцлогийг хэл яриа, аж байдлаар нь тусгаж чаддаг оршихоос гадна байгалийн байдал, нийгмийн харьцаа ба монголчуудын эртнээс нааш мал аж ахуйг эрхлэн, нүүдэлчин амьдралыг харуулдаг.	“Түс гэдэг годилоор ан хийж амьдарч байгаа хүү”-гийн дүрээр ан агнуур хийн, загас барьж амьдардаг нүүдэлч ард түмний төлөөллийг гарган харуулсан. <a href="#">Монгол хүний</a> оюун санаанд эртнээс нааш уламжлан ирсэн шүтлэг бол бөө мөргөл гэдгийг үлгэрт “... бөө хүн цагаан малгай, цагаан дээлээ өмсөөд, цагаан морио унаад гараад явав” (2011, х.503) гэсэн хэсэгт тодорхой харагдана.	Хятад улс нь сууршмал соёлтой учир үлгэртээ хаант засаглалыг тусган гаргасан агаад хаан хүн ард олноо гэсэн нинжин сэтгэлтэй байх ёстой гэдгийг харуулсан.  Мөн эрт дээр үеэс бийр, муутуугаараа алдартай агаад үлгэрт тусаж буй “бийрээр зурсан зураг”-ийн өгүүлэмжээс тодорхой харагдана.	Хятад улс нь суурин соёл иргэншилтэй бөгөөд үлгэрийн үйл явдал газрын эзний гэр, гол мөрн, түлээ бэлддэг газрын хооронд л үйл явдал өрнөж байгаа. Үлгэрт өгүүлэгдэж буй газрын эзний дүр нь феодалын байгуулал, хамжлага бүхий нийгмийн газар эзэмшигч хүний дүрийг тодорхой тусгасан.

3.	Бэлгэдэл	<p>Үлгэр дэх “Мөнгөн таяг”-аар урт нас, буян хишиг, өмөг түшиг, хүмүүнлэг чанарыг бэлгэдсэн. Мөн “Мөнгөн буйл, мөнгөн хуруувч, мөнгөн зул”-ын бэлгэдэл нь эд баялгыг бэлгэдэх утга бас бий. Журга нумаар хүч, чадал дорой нум сумыг үлгэрт тусгасан нь Өнчин Бэглэгийг сул доройвтор хүү гэдгийг тодотгосон.</p>	<p>“...цагаан малгай, цагаан дээлээ өмсөөд, цагаан морио унаад” гэсэн нь цагаан сарын шинийн нэгэнд цагаан дээл, малгай өмсч, цагаан морь унадаг байсан нь аливаа хар үйлийг цагаалан цайлгах бэлгэдлийн утгатай. “цал буурал, цагаан сахалтай өвгөн цагаан мөнгөн таяг” гэсэн хэсэгт гэгээрэлд хүрэх, амгалан урт наслахыг өвгөн хүний дүрээр дүрсэлдэг. Цагаан өнгийн хадгийг хүндэтгэдэг хүндээ барьдаг.</p>	<p>Уг хүүгийн бийртэй болох хүсэл мөрөөдөл зүүдэнд нь биелдэг.</p> <p>“урт буурал сахалтай өвгөн”-ий дүр нь оюуны чанд гэгээрэлд хүрэх, энх амгалан урт наслахын бэлгэдлийг өвгөн хүний дүрээр дүрслэн үзүүлдэг билээ.</p> <p>Дотоод сэтгэлийг төлөөлүүлэн бэлгэдсэн болно. Учир нь өөрийн төлөө бус бусдын төлөө гэсэн зөв сэтгэлтэйгээр үлгэрт дүрслэгдсэн болно.</p>	<p>Мөн тус үлгэрт гурван янзын сүх гаргасан гурван оролдлого, гурван хүсэл, гэсэн ойлголтууд байдаг. Хятад улс нь лус савдаг шүтэж, урт цагаан сахалтай өвгөнөөр бэлгэдэл зүйг дүрсэлсэн.</p> <p>“Толын ус эмгэнэн, цалгилав” гэдэг нь амьдралыг тэтгэгч рашаан, мөнх амьдрал, ариун байдал, буртаг бүхнийг ариусгагч шинжийг бэлгэдэн дүрсэлсэн байж болох юм.</p>
----	----------	--	---	---	---

### Дүгнэлт

Бид өнчин хүүгийн дүр туссан үлгэрүүдэд дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Адил тал: Монгол ардын болон Хятад ардын үлгэрүүдэд өдөр хоногийг дүнгэн данган өнгөрөөж байгаа хэдий ч илүү харж, шуналтах сэтгэлгүй, аз жаргалынхаа төлөө тэмцэж чаддаг үнэнч дүр, цагаан өвгөний дүр дүрслэл үлгэрүүдэд адилхан илэрч байна.
2. Ялгаатай тал: Монгол ардын үлгэрт туссан өнчин Бэглэг, Өнчин Бүш хүү нар нь ан гөрөө хийж, амин хувиа борлуулдаг, сэргэлэн, зальжин шинж байдлыг тодруулан гаргасан тэмцэгч дүрийг үлгэрт тусгасан бол Хятад ардын үлгэрт Ма-лин хүү, Цзен ши хүүгийн дүрүүд нь айлд зарцлагдаж буй шинж байдлыг тусгасан дарлагдагч дүрийн төлөөлөл мөн болно.
3. Өнчин хүүтэй үлгэр болгон ямар нэгэн туслах дүртэй байдаг. Монгол соёлын илрэл буюу таван хошуу малтай шууд холбогддог. Монгол ардын үлгэрүүдэд хамуутай бор даага, ганц морь нь өнчин хүүг аюулаас гэтэлгэж, зөв замаа олоход нь тусалж буйгаар ихэвчлэн дүрслэгдсэн байдаг бол Хятад ардын үлгэрт харин өнчин хүүг эд зүйл (бийр, сүх зэрэг) нь хамгаалан, тусалж буйгаар дүрслэгддэг.
4. Монгол ардын үлгэрт бөө мөргөл, мөнгөн эдлэл, урт сахалт цагаан өвгөн, цагаан хадаг, цагаан дээл хувцас зэрэг бэлгэдэл, хүндэтгэлийн шинжийг тусган өгсөн ба Хятад ардын үлгэрт урт сахалт, цагаан өвгөн, лусын эзэн, алт, мөнгөн эдлэлийг тус бүр тусган өгснөөрөө онцлог болно.
5. Хятад ардын үлгэрт газрын эзэд болоод баяд ноёдын мөн чанар нь ард түмнийг

мөлжиж тонох, залилан мэхлэх, жигшүүрт явдлыг үлгэрт харуулсан. Харин Монгол ардын үлгэрт нийгэм ба хувь хүний хоорондын өв тэгш харилцаа, шударга ариун ёс, тэгш байдал дээр тулгуурлан нийгмийн бурангуй байдлыг тусгасан болно.

### Ашигласан материал

- Гаадамба, Ш. (1988). Монгол ардын аман зохиол. Улаанбаатар: ШУА. Хэл зохиолын хүрээлэн
- Дайриймаа, Б. (2013). Монгол ардын үлгэрийн баатруудын уран дүрслэлийн онцлог. Улаанбаатар: ШУА. Хэл зохиолын хүрээлэн3
- Дайриймаа, Б. (2017). Монгол ардын шидэт үлгэрийн өгүүлэмж. Улаанбаатар: ШУА. Хэл зохиолын хүрээлэн
- Дамдинсүрэн, Ц. (1978). Монгол ардын аман зохиолын дээж бичиг. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар
- Дулам, С. (1999). Монгол бэлгэдэл зүй. Улаанбаатар: ADMON
- Дулам, С. (2011). Тооны бэлгэдэл зүй. Улаанбаатар: Бит пресс
- Цэрэнсодном, Д. (2011). Монгол аман зохиолын тайлбарт дээж бичиг. Улаанбаатар: Тод бичиг
- Дүүрэн, Т., Дөлгөөн, Т. (орч). (1997). Шувууны хэл. Улаанбаатар: БЕМБИ
- Сосорбарам, Э. (хөр). (1964). Алтан сүх. Улаанбаатар: Хэвлэлийн комбинат
- Хөвсгөл, С. (2011). Харьцуулсан аман зохиолын асуудлууд. Улаанбаатар: Бэмби сан